



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 04 сарын 11 өдөр

Дугаар А/233

Мөрөн

Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх
ажлыг эрчимжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29.1.3.-ийн "а", Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн 4.5.1, 4.5.3, Төвсийн тухай хуулийн 58.2.12 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Мал, амьтныг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх, оношлох арга хэмжээг жил бүрийн эпизоотологийн судалгаанд тулгуурлан сумдын Засаг дарга болон, Мал эмнэлэг, үржлийн тасагтай гэрээ байгуулан чанартай зохион байгуулж ажиллахыг Хүнс, Хөдөө аж ахуйн газрын дарга /Г.Баттулга/-д даалгасугай.

2. Мал, амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээний гэрээнд заасан ажил үйлчилгээний хөлсний 10 хүртэл хувийн урьдчилгаа санхүүжилтийг урьдчилан сэргийлэх арга хэмжээний бэлтгэл, хяналт хийх үйл ажиллагаанд зориулж олгож байхыг Хүнс, Хөдөө аж ахуйн газрын дарга /Г.Баттулга/-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Х.Ган-Очир/-д үүрэг болгосугай.

ОРЛОГЧ

Ц.БАТТОГТОХ



01110533